

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 20/01/01

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1. дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ**
НЬ:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн анхдугаар хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Г.Оюунболдыг ТУЗ-ийн даргаар сонгосугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ТУЗ-ийг удирдан зохион байгуулж ажиллахыг Г.Оюунболдод үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

1. Ц.Нэргүй
2. Г.Алтаймаа
3. Б.Отгонтуяа
4. А.Ариун-Эрдэнэ
5. Г.Санжаасүрэн
6. Г.Оюунболд
7. Камолидин Талипов
8. Х.Батзаяа
9. Б.Хосбаяр



“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 20/01/ 02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8. дах заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн анхдугаар хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Э.Саранчимэгийг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нарийн бичгийн даргын эрх үүргийг үндэслэн Э.Саранчимэгтэй байгуулах ажил гүйцэтгэх гэрээг хавсралтаар баталсугай.
3. ТУЗ-ийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Г.Оюунболдод зөвшөөрсүгэй.
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон ажил гүйцэтгэх гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Э.Саранчимэгт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 20/01/03

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8. дах заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн хуралд оролцсон 9 гишүүний 100 хувийн саналаар Ганбат овогтой Гомбыг компанийн гүйцэтгэх захирлаар улируулан сонгосугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд нийцүүлэн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээг хавсралтаар баталж, уг гэрээнд ТУЗ-ийг төлөөлөн гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Г.Оюунболдод зөвшөөрсүгэй.
3. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, хөлсөөр ажиллах гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Г.Гомбод үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 20/01/04.

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ХОРООДЫГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2. дах заалт, ТУЗ-ийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Ц.Нэргүй/Дарга/
 2. Б.Хосбаяр
 3. Г.Алтаймаа
2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Х.Батзаяа /Дарга/
 2. Г.Оюунболд
 3. Ц.Нэргүй
3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Ц.Нэргүй/Дарга/
 2. А.Ариун-Эрдэнэ
 3. Б.Хосбаяр
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА**Г.ОЮУНБОЛД**